

“МАШ ГАЙХАМШИГТ БАЯСГАЛАНГИЙН ХУРМЫН САН”-Д  
БҮЙ НҮДНИЙ ӨВЧНИЙГ ЭМЧЛЭХ АРГЫГ ТОДРУУЛАХ НЬ

Ванглин<sup>1</sup>, Энхжин Г<sup>2</sup>, Молор-Эрдэнэ П<sup>1</sup>, Ш.Болд<sup>2</sup>

TREATMENT METHODS OF EYE DISEASES IN THE  
“NGO MTSCHAR DGA’ STON GTER MDZOD”

Wanglin, G.Enkhjin, P.Molor-Erdene, Sh.Bold

<sup>1</sup>International School of Mongolian Medicine

<sup>2</sup>Mongolian National University of Medical Sciences

**Abstract**

Prescriptions of Iron decoction-5, Brightness-7 mixed medicine, Sun-17 and Brightness-30 are used in practice in Inner Mongolian Autonomous Region of China. However these prescriptions are just a few of the medicines used for eye diseases and there are dozens of unexplored prescriptions. The source study of traditional medicine is the main research direction to facilitate this kind of research. We have examined the treatment methods of eye diseases from the book *gso rig gzhung mang bsdus pa'i bdud rtsi'i snying po tsha grang zug rngu sel ba'i ngo mtshar dga' ston gter mdzod zhes bya ba bzhugs so by Choijamts*. The study found that the main cause of eye disease is damage in one or combination of wind, bile, phlegm, blood and identified several interesting prescriptions and interpreted its names in Mongolian, including *mun sel nyi ma'i dkyil 'khor*, *a gar mchog bdun*, *gsal byed bcu gsum*, *ring srel phan byed*, *rdo rje khrag 'joms*. In addition, eye diseases were generally treated by *mun sel nyi ma'i dkyil 'khor*, *a gar mchog bdun*, *gsal byed bcu gsum*, *ring srel phan byed*, *rdo rje khrag 'joms* decoctions.

There are a number of interesting methods of treating eye diseases within the one scripture used in the study, and furthermore it is necessary to further study each of these methods and to introduce them into curriculum of ophthalmology of traditional medicine subject.

**Key words:** Prescription, medicine, eye diseases, traditional medicine

**Үндэслэл**

БНХАУ-ын ӨМӨЗО-д төмрийн талх-5 тан, тодотгогч -7-гийн зуурмал, нүдний өвчнийг арилгагч, нар-17, зэс өвс-7, зэс өвс-15, тодотгогч-30, төмөр үрэл, зэв чулуу-25 гэсэн эм найрлагыг нүдний өвчний эмчилгээнд хэрэглэж байна. Гэвч эдгээр жорууд нүдний өвчинд хэрэглэж байсан эмийн цөөхөн хэсэг нь бөгөөд цаана нь судлагдаагүй, хөндөгдөөгүй олон арван жорууд байна. Үүнийг шийдвэрлэхэд чухал түлхэц болох судалгааны чиглэл нь уламжлалт анагаах ухааны сурвалж бичгийн судлал юм<sup>1</sup>.

Уламжлалт анагаах ухааны сурвалж бичгийн судлал нь Монголын түүх, нийгмийн ухаан, утга зохиолын сурвалж бичгийг бодвол

харьцангуй залуу салбар бөгөөд үүн дотроо эмийн судрын орчуулга, судалгаа тун бага хийгдэж байна. Үүнээс шалтгаалаад эмийн түүхий эд, эм найрлагын хэрэглээний утгыг үл онох, төөрөгдөлд хүрэх эрсдэл гарах боломжтой юм<sup>2</sup>. Цаашлаад утгын төөрөгдөл нь эмчилгээний үр дүнд сөргөөр нөлөөлж болох юм.

Түүнчлэн уламжлалт анагаах ухааны эмийн судар номыг судлан эмийн түүхий эд, эм найрлагын тус эрдэм, хэрэглээг үнэн зөв тодорхойлж танихгүйгээр уламжлалт анагаах ухааныг бүтээлчээр хөгжүүлж, эмийн нэр, төрлийг олшруулан хүн амын өсөн нэмэгдэж буй хэрэгцээг богино хугацаанд хангаж чадахгүй юм.

## Зорилго

Гэлэн Чойжамцын “Маш гайхамшигт баясгалангийн хурмын сан” судар дахь нүдний эмчилгээний аргыг тодруулан, зарим эмийн нэр хэрэглээнд тайлбар хийх зорилго тавив.

## Судалгааны материал ба арга

### Үндсэн материал

Гэлэн Чойжамц. གསོ་རིག་གཞུང་མང་བསྐྱེས་པའི་བདེ་སྤྱི་སྤྱི་པོ་ཚ་གང་ལྷག་ལྷ་སེམ་བའི་ངོ་མཚར་དགའ་སྟོན་གཏོར་མཛོད་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ། “Анагаах ухааны олон гол сурвалжаас хураасан рашааны шим, халуун, хүйтний энэлгээг арилгагч маш гайхамшигт баясгалангийн хуримын сан хэмээх оршивай” модон барын төвөд судар.

### Судалгааны арга

Эх бичиг, сурвалж бичгийн судлалын арга

Уг судалгааны арга нь сурвалж бичгийн эх, нэр, зохиогч, газар орон, онцлог, агуулга, тайлбар, харьцуулга, хөрвүүлэг зэргийг нэгэн дор хамтатган судлахад оршдог.

Бид судалгаанд ашигласан материалаа ажлынхаа зорилгод нийцүүлэн бичигдсэн цаг хугацааг эрт үеэс нь эхлэн эрэмбэлж судалгааг явуулан улмаар бүтээлийн гол агуулга, шинэлэг санааг шүүн тунгааж үзлээ. Мөн зохиолын дотор агуулагдах нүдний эмийн эмчилгээний аргатай холбоотой мэдээллийг сонгон авч тайлбар хийж баяжуулан, зарим нэр томъёонд тайлбар хийв.

### Үр дүн

Нүдний өвчин хий, шар, бадган цуснаас үүсэх нь олонтаа байдаг. Хийн гэмээр өвчилвөл судал улайж овойх бөгөөд жавар салхи хорлох олонтой. Шарын гэмээр өвчилвөл өнгө нь шарлаж халуун оргих бөгөөд нулимс элбэгшинэ. Бадганы гэмээр өвчилвөл хавдаж, нулимс цувирна. Бадган, хий хавсарч үүссэн өвчин бол гал мэт халуун оргиж хатан, ширүүн, аргах бөгөөд цус, шар хавсарч үүссэн өвчин бол махан үүл тогтож, зузаарна<sup>3</sup>.

Эвэршээл болон нуух нулимс асгарах нь бага, хавдаргүй, нүдний судал халуун, хүйтэн,

бүрэлзэх ба цагаа зэрэг тасын нүд мэт сүр жавхлантай, дуртмал болгон тэтгэн хувиргах эм найрлагууд байдаг. Үүнд:

Мүнсэл нямай жинхор (mun sel nyi ma'i dkyil 'khor),

Хий-д агарчогдүн (a gar mchog bdun),

Шар-д бол салжид-13 (gsal byed bcu gsum) -г өг.

Бадганд ринсрэлпанжид (ring srel phan byed),

Цусанд доржтагжом (rdo rje khrag 'joms) тан өг.

Ерөнхий эмэнд: аваа-15 (a lba bco lnga), гүргэм-9 (gur gum dgu ba), дүдзидашил (bdud rtsi zla shel), гүргэм-6 (gur gum drug pa)

(Хүснэгт 1).

Table 1.

**Eye treatment method displayed by table**

No	Cause of eye disease	Main symptom	Main medicine (Supportive medication change to clear vision like royalty vulture eye)	Mani medication
1	Khii	Blood vessel redden and roughen. Exacerbated by wind & cold.	Agarchogdun (a gar mchog bdun)	Ava-15 (a lba bco lnga),
2	Shar	Clor yellowish, become hot. Plenty of tears from eye	Saljid-13 (gsal byed bcu gsum)	
3	Badgan	swelling, tears from eye	Rinsrelpanjid (ring srel phan byed)	Gurgem-9 (gur gum dgu ba),
4	Badgan Khii	Become hot like fire, thirsty,harsh, dry		
5	Blood Shar	Pterigium	Dorjtagjom (rdo rje khrag 'joms)	Dudzidashil (bdud rtsi zla shel)  Gurgem-6 (gur gum drug pa)

Нүдний цагаад чүмигжүджд (chu mig bcud bskyed), мигванжүджд (mig dbang bcud byed), дүдзигүнжүн (bdud rtsi kun 'byung), хятадын цагаан эм, өдний гуурст хийгээд цагаан шаазан хумхат алин боловч дээд гэж үздэг. Мөн баавгайн цөс, зод, жажиг, номхотгосон цала, жанбүл, хач гүргэм, алтан өнгөт арүр, хүдрийн заарыг нүдэж нунтаглаад торгонд хуйлж зэс аяганы дотор долоо хоног дэвтээж, шүүсний тунгалгийг нүдэнд хийнэ.

Жамусалжид хэмээх эм нь сохор бүхнийг эдгээнэ. Тиймээс хатгуур хэрэггүй хэмээн номложээ<sup>4</sup>.

Түүнчлэн нүдний өвчин туссан үед олон янзын тарнийг урьж унших нь ихээхэн ач холбогдолтой байдаг. Тарнийг санскритаар धारणी (dharani) хэмээдэг. Сөрөг төлөв байдал, гэмээс хамгаалах, бие махбодын аль нэгэн оронд гэм оршсон үед түүнийг арилгах, эмчлэхэд эерэг нөлөө үзүүлдэг, олон унших тусам үйлдэл нь гарах хоршоо үгнүүд юм<sup>5</sup>.

Нүдний халуун өвчинд унших тарнийг “Ум

лансон лин лод” хэмээн урих бөгөөд нүдний гадна эм тахианы өндгийг нэг хоногийн турш нүднээс салгалгүй бариад энэ тарнийг аль болох олон өгүүлбээс нүдний халуун өвчнийг арилгахын дээд.

Нүдний хижгийг сахих нь: “Ум дрин дри дрин дри сад сад дэва еэ суухаа”. “Чад во ва ла миг ги рим сүрэншиг рагча, миг над тод сүрэншиг рагча” хэмээн урьж бичээд аравнайлна<sup>6</sup>.

“Маш гайхамшигт баясгалангийн хурмын сан” сударт зөвхөн Монгол, Төвөдийн эмчилгээний аргаас гадна Хятад мэргэдийн эмийн эмчилгээний аргын талаар цөөнгүй дурдсан байдаг. Тухайлбал Хятад мэргэдийн увдис нүдний сохрыг арилгах эмийг онцлон тэмдэглэжээ (Хүснэгт 2).

Table 2.

**Rule to compound medicine initially, month, day**

Months to compound medicine	Tiger	Rabbit	Dragon	Snake	Horse	Goat	Monkey	Rooster	Dog	Pig	Rat	Ox
Day to compound medicine	2	5	4	9	10	20	15	27	29	18	1	1

Илүү сар тэргүүтэн энэ нь урьд сартай адил. Эм нь: Хангүн (han kun), жамцойвува (rgya mtsho'i lbu ba), хонлинсэрбо (hong len ser po), бүтүнли (bu thung li) зэргийг хувь тэнцүү найруулж нунтаглан нүдэж, зэс саванд хийж буцалгаад, гуравны хоёр хувийг ширгээж, нэг хувийг шавар бумбанд хийж, газар дор булаад хорин нэг хоног өнгөрхөд гарган авбал чадал хэмжээ бүрдэн, сохорсон нүдийг угаавал магад эдгэнэ. Арван таван жил нүд нь сохор байсан нэгэн тавин гурван насандаа энэ эмийг түрхээд нүд сохорсон өвчнөөс салсан хэмээн ярилцдаг, дамжиггүй увдис мөн.

Могойн хүүр нэгийг, хилэнцэт хорхойн хүүр дөрөв зэргийг хорин нэг хоног гашилсан сүүнд дараад, түүнийг бүлсэн тосыг тахианд өгч идүүлэн, тэр тахианы сангасыг сохорсон нүдэнд түрхвэл тустай гэдэг.

Тас шувууны толгойн яс, үхрийн хэлний үнс, ногоолиг чулуу зэргийг хувь тэнцүү нунтаглан тавь. Зэндмэнэ, гантиг 030, шил гавар 030, сувд 050, донрой 030, жонш 001 эдгээрийг найруулж, нарийн нунтагласныг нүдэнд хуурайгаар хийвэл махан үү нь урагдаж, эвэршсэн үүл, торлосон судал, үдшийн харалган, нулимс хямарсан ба гадна, дотно бүрхэвч, нүдний цөцгийн өнгө доройтсон зэрэг өвчнүүдэд тустай. Товчилбол нүдний өвчин гучин гурвыг, үйлийн эрхээр болсноос бусдыг арилгах нь олтгой үгүй. Эдгээр эм заслыг хурц оюунаар эндүүрэлгүй анагаавал харанхуй

сохрын зовлонгоос гэтэлж, баярын наран мандана хэмээжээ.

Судалгаанд авсан ганцхан судрын хүрээнд нүдний өвчний эмчилгээний талаар дээр дурдсан сонирхол татахуйц аргууд цөөнгүй байгаа нь тогтоогдож байгаа бөгөөд цаашид эдгээр арга тус бүрийг нарийвчлан судлах, хэлэлцүүлэг зохион байгуулах, сургалтын хөтөлбөрт оруулах, уламжлалт анагаах ухааны нүдний өвчин судлалын хичээлийг шинээр заан сургах зайлшгүй шаардлага бий болсоор байна.

**Ном зүй**

1. Болд.Ш. "Монголын уламжлалт анагаах ухааны хөгжлийг эх сурвалжийн судалгаагаар тодруулах нь". Анагаахын шинжлэх ухааны докторын зэрэг горилсон нэгэн сэдэвт зохиол. УБ, 2005
2. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. – УБ.: ADMON ХҮ, 2006
3. Чойжамц. གསོ་རིག་གཞུང་མང་བསྐྱེས་པའི་བདེ་སྲོལ་ལོ་ཚྭ་གང་ལུག་རྒྱ་ལེ་བའི་དོ་མཚན་དགའ་སྟོན་གཏེར་མཛོད་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ། Анагаах ухааны олон гол сурвалжаас хураасан рашааны шим, халуун, хүйтний энэлгээг арилгагч маш гайхамшигт баясгалангийн хуримын сан хэмээх оршивай. Модон барын төвөд судар. Нийслэл Хүрээ, 1922.
4. Чойжамц. གསོ་རིག་གཞུང་མང་བསྐྱེས་པའི་བདེ་སྲོལ་ལོ་ཚྭ་གང་ལུག་རྒྱ་ལེ་བའི་དོ་མཚན་དགའ་སྟོན་གཏེར་མཛོད་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ། Анагаах

ухааны олон гол сурвалжаас хураасан рашааны шим, халуун, хүйтний энэлгээг арилгагч маш гайхамшигт баясгалангийн хуримын сан хэмээх оршивай. Модон барын төвөд судар. Нийслэл Хүрээ, 1922.

5. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. – УБ.: ADMON ХҮ, 2006

6. Чойжамц.གསོ་རིག་གཞུང་མང་བསྐྱེས་པའི་བདུན་རྩེད་སྦྱིང་པོ་ཚ་གུང་ལྷག་རྩ་སེལ་བའི་ངོ་མཚར་དགའ་སྟོན་གཏིར་མཛོད་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ། Анагаах ухааны олон гол сурвалжаас хураасан

рашааны шим, халуун, хүйтний энэлгээг арилгагч маш гайхамшигт баясгалангийн хуримын сан хэмээх оршивай. Модон барын төвөд судар. Нийслэл Хүрээ, 1922.

7. Чойжамц.གསོ་རིག་གཞུང་མང་བསྐྱེས་པའི་བདུན་རྩེད་སྦྱིང་པོ་ཚ་གུང་ལྷག་རྩ་སེལ་བའི་ངོ་མཚར་དགའ་སྟོན་གཏིར་མཛོད་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ། Анагаах ухааны олон гол сурвалжаас хураасан рашааны шим, халуун, хүйтний энэлгээг арилгагч маш гайхамшигт баясгалангийн хуримын сан хэмээх оршивай. Модон барын төвөд судар. Нийслэл Хүрээ, 1922.

*Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:  
Академич Л.Цэрэндулам*